Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 20.....
оны ..... дүгээр сарын ......-ны өдрийн ..........
дугаар албан бичгийн хавсралт

# ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР, ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

/2024 оны 05 дугаар сарын хэрэгжилт/

2024 оны 05 дугаар сарын 28 Улаанбаатар хот

| Шийд-вэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц (2000 тэмдэгтэд багтаана) | Үнэл-гээ | Б/га |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | |
| Засгийн газрын тогтоол | | | | | | |
| 7 | 9 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7 | 5.Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай:<br>5.1.эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;<br>5.2.төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;<br>5.3.төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; | | | Нийт байгууллагууд |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 5.4.төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5.төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | | | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | |
| 88 | 149 | 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2022-09-28 Дугаар 2022_47 | IX.1.16.Нийтийн тээврийн автобусны тоог нэмэгдүүлэх, автобусны терминал, бааз байгуулах ажлыг эрчимжүүлэхийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | 2024 оны 01 дүгээр улирлын байдлаар нийтийн тээврийн салбарт 600 тээврийн хэрэгслээр парк шинэчлэлт хийгдсэн бөгөөд тээврийн хэрэгслийг үйлчилгээнд гаргах ажлын хүрээнд 9 аж ахуйн нэгж, байгууллагын 27 чиглэлийн гаралтын тоог үе шаттайгаар нэмж нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэн, автобус хоорондын хүлээгдлийн хугацааг бууруулан өдөрт үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн тоог 1132 болгон нэмэгдүүлсэн. Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах тендерт шалгарсан Гео зураглал ХХК-тай 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ЭЗХЯ/94 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна. Дээрх ажлын хүрээнд Офицеруудын ордон, 120 мянгат орчимд 5 байршилд нийтийн тээврийн терминал байгуулах зураг төслийг гүйцэтгүүлэн авсан бөгөөд 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Геозураглал ХХК болон Нийтийн тээврийн газрын холбогдох мэргэжилтнүүд газар чөлөөлөх боломжтой байршлыг судлан газар дээр нь ажиллан сонгосон байршлын газар чөлөөлөх ажлыг зохион байгуулах талаар 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 01/02/872 дугаартай албан бичгээр Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах ажлын хүрээнд сонгогдсон хоёр байршилд ажлын даалгавар гарган өгөх талаар Хот байгуулалт, хөгжлийн газарт 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 01/06/1108 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Нийтийн тээврийн нэг маягийн терминал байгуулахаар төлөвлөсөн байршил нь нийтийн хэрэгцээний газрыг дайрч байгаа тул газар чөлөөлөлт хийгдэж терминал байгуулах боломжтой эсэх талаар, мөн газар чөлөөлөх зардлыг | | ННТБГ |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | төсөвт тусгуулах талаар 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 01/02/1386 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 28 дугаар тогтоолоор 2024 оны II улиралд багтаан Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ыг байгуулахаар тогтоосны дагуу нийтийн тээврийн үйлчилгээг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. Мөн Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/110 дугаар захирамжаар 150 тээврийн хэрэгслийн багтаамжтай Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын 3-р баазын үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотойгоор Наадамчдын замаар зорчих тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэх, сул километрийг багасгах үүднээс 10 чиглэлийг шилжүүлэх ажил хийгдсэн. | | |
| 88 | 150 | 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2022-09-28 Дугаар 2022_47 | IX.1.17.Нийтийн тээврийн салбарын удирдлага, зохион байгуулалт, менежментийг өөрчлөх, шинэчлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | ЗУХ | | ННТБГ |
| 88 | 153 | 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2022-10-10 Дугаар 2022_49 | XII.6.Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт даалгав: 1.Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн парк шинэчлэлтийг хийж, чанар, хүртээмжийг эрс сайжруулах, үйлчилгээний стандартыг тогтоох, нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийг шинэчлэн төлөвлөж, хэрэгжилтийг хангах;<br>2.Нийтийн тээврийн удирдлага, зохион байгуулалт, тулгамдсан бусад асуудлыг | Автозамын нэгдүгээр эгнээний зорчих хэсгийг чөлөөлснөөр нийтийн тээврийн үйлчилгээний шинэчилсэн төлөвлөлтийг хэрэгжүүлэх боломж бүрдэх бөгөөд өнөөгийн нийтийн тээврийн төлөвлөлтийг олон улсад “Дотогш чиглэсэн хөдөлгөөн” /liner trunk diameter/ гэж томьёолдог. Энэ төлөвлөлт нь Улаанбаатар хотын гол гудамж замуудад чиглэлийн тээврийн хэрэгслийн давхцалыг ихээхэн үүсгэж байна. Иймд нийтийн тээврийн чиглэлийн дахин төлөвлөлтийг хийх зайлшгүй шаардлага үүссэн бөгөөд Улаанбаатар хотын газар зүйн хэлбэр болон одоо байгаа авто замын сүлжээнд тулгуурлан сарнисан тойрог хөдөлгөөний төлөвлөлтийг боловсруулсан. /Grid Diffuse network/. Уг нийтийн тээврийн сүлжээний төлөвлөлт нь зорчигчийг хотын аль нэг захаас нөгөө зах руу заавал дамжин суух нөхцөлийг бүрдүүлэхийг зорьсон бөгөөд дамжин суулт хийх үед автобусны хүлээгдлийн хугацааг хамгийн бага, | Хасах санал | ННТБГ |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | шийдвэрлэх ажлын төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, ажлын явц байдлыг Засгийн газарт танилцуулж ажиллах; | багтаамж ашиглалтыг хэвийн хэмжээнд тогтоох тооцооллыг хийн ажилласан. | | |
| 88 | 168 | 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2022-09-28 Дугаар 2022_47 | Х.4.1.Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах хүрээнд улс, нийслэлийн төсвийн хөрөнгө болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, тэдгээрийн уялдаа холбоо, үр дүнгийн талаар Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүд, бусад албан тушаалтанд даалгав: 1.“Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд Улаанбаатар хотын авто замын сүлжээний хөндлөн чиглэлд хэрэгжих “Тусгай замын их багтаамжийн автобус төсөл” (BRT)-ийг 2023 онд багтаан эхлүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Нийслэл Улаанбаатар хотын тээврийн зорчилтыг нэмэгдүүлэх ТТ 6688 МОН төслийн хүрээнд хэрэгжүүлэх “Тусгай замын автобусны төлөвлөлт ба зураг төсөл сэдэвт семинар” 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан. Тухайн семинарт Far East BRT Planning Co., Limited. Компани нийтийн тээврийн тусгай замын автобус зорчих төлөвлөсөн трассыг танилцуулах болон хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Far East Mobility зөвлөх компанийн урьдчилсан судалгаагаар 21-р хороолол, Толгойт – Ард Аюушийн өргөн чөлөөг холбох шинэ гудамж замын дагууд Их тойруу, Сансарын тойрог хүртэл 12.6 км трассыг урьдчилсан байдлаар тогтоосон. “Улаанбаатар хотын хөдөлгөөнийг сайжруулах (55245-001) төсөл”-ийн хүрээнд Урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, хянан магадлах зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт зарлсантай холбогдуулан ажлын даалгаварт 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 01/02/1256 дугаартай албан бичгээр Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах төсөл хэрэгжүүлэх нэгжид саналыг хүргүүлсэн. | | ННТБГ |
| 101 | 173 | 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 16 дугаар тэмдэглэл 2023-04-12 | ХХ.1.4.Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар Монгол Улсын сайд, нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны | Монгол Улсын Сайд, Нийслэл Улаанбаатар хотын автозамын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 01/681 тоот албан бичгээр Нийслэлийн Нийтийн тээврийн газрын даргад ирүүлсэн 02 дугаартай Зөвлөмж, эрх бүхий албан тушаалтнуудтай зөвшилцсөний үндсэн дээр нийт 74 чиглэлд 1075 автобусаар | | ННТБГ |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2023_16 | дарга Ж.Сүхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав: Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд нийтийн тээврийн системийн шинэчлэл, маршрут төлөвлөлт, эргэлт зохицуулалтын талаар 2023 оны 04 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав. | үйлчилгээг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс хэрэгжүүлсэн. Тухайлбал, Энхтайваны өргөн чөлөө, Чингэлтэйн өргөн чөлөө, Чингисийн өргөн чөлөөнөөс Наадамчдын зам, Их тойруугийн гудамж, Нарны зам, Хүннүгийн гудамжаар нийт 6 чиглэлд 375 автобус, дээрх 6 урт чиглэлийг холбосон 8 тойрог чиглэлд 92 автобус, бусад гудамж замуудаар үйлчлэх үндсэн 40 богино эргэлтийн чиглэлд 494 автобус, хот орчмын 15 чиглэлд 89 автобус, их багтаамжийн автобус явах боломжгүй хотын захын хорооллуудаар үйлчилгээ үзүүлэх дунд багтаамжийн 5 чиглэлд 25 автобус үйлчилгээнд ажилласан. Нийтийн тээврийн зорчигчдоос ирүүлсэн саналыг үндэслэн 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн хуучин 71 чиглэлийг сэргээсэн. Мөн дахин төлөвлөлтийн хүрээнд чиглэлийн тээврийн хэрэгслийн 209 зогсоолын мэдээллийн самбарт дахин төлөвлөлтийн ерөнхий мэдээллийг байршуулсан. | | |
| ЗГ-ын албан даалгавар | | | | | | |
| 149 | 279 | 2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-01-12 Дугаар 2024_01 | 4.4.Автобус, нийтийн тээврийн хэрэгслийн парк шинэчлэлийн ажлыг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан хийж дуусгахыг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт; | БТеТХ | | ННТБГ |
| | | | 1.“Нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г хавсралтаар тогтоосугай. | | | |